


I-V ангийн зөв бичих чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
БИЧИХ ЧАДВАР					
Бичих чадварт тавигдах шаардлага	Үсгийг зурлагын дагуу зөв бичих, үг холбон, өгүүлбэрийг том үсгээр бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дэгийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дэгийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих
Зөв бичих	1.2.а. Хуулж болон цээжээр бичихдээ үсэг, үг, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих	2.2.а. [н,г] үсгээр утга ялгах үсгийг зөв унших, нүдлэх, зөв бичих	"3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх"	4.2а. Дуудлага ихил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах өгүүлбэрт зөв бичих (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл)	5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах
	1.2.б. Хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх	2.2.б. Эр, эм үг үгэнд "ы, ий" залгаврыг зөв залган бичих	"3.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх"	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	5.2.б. Үйл үг бүтээх "-л" дагаврын дүрмийг мэдэх, зөв бичих
		2.2.в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих	"3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих"	4.2в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	
		2.2.г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх	3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



1 Үгсийг ангилан бичээрэй.



Хэлний "г"-тэй үг

Хоолойн "г"-тэй үг



Хэлний үзүүрийн "н"-тэй үг

Хэлний угийн "н"-тэй үг

2 Холбоо үг үүсгэн харгалзуулаарай.

А. хээтэй

тараг

Б. уураг

шанд

хүрэн

баг

бага

сүү

элгэн

торго

тарга

дүү

нүүрний

булга

булаг

тэвээрэг

3 Өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохиож бичээрэй.

өрөг

өргө

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: 1 2 3



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Дуудлага ижил үгсээс үйл үгийг ялгахын тулд үйлт нэрийн “х” –ийн өмнө эгшиг бичнэ. Жишээ өрх – өрөх, торх – торох, бүрх- бүрэх

1 Зургийг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

			
торх сав	нүдэнд торох	сэрх ямаа	өглөө
			
нялх хүүхэд	будаг	шарх сорви	мах

2 Дараах үгсийг уншаад, нэр үгийг , үйл үгийг өнгөөр будаарай.

сэрэх

сэрх

хонх

хонох

живх

живэх

нялх

нялах

өрх

өрөх

төрөх

төрх

3 Цэгийн оронд үг нөхөж, холбоо үг үүсгээрэй.

.....харх,хараххонх,хонох
хавх,хавахшарх,шарах
сэрх,сэрэхсавх,савах

4 Дараах үгсээр утгыг гарган өгүүлбэр зохиож бичээрэй.

нялх

нялах

төрх

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

1

2

3

4



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



- Эгшигт гийгүүлэгчийн дараа эгшигт гийгүүлэгч орвол эгшигтэй бичигдэнэ. Жишээ нь нэ**мэр**, на**мар** $7+7=Э$
- Заримдаг гийгүүлэгчийн дараа эгшигт гийгүүлэгч орвол эгшигтэй бичигдэнэ. Жишээ санд**ал** $9+7=Э$
- Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол хоёр дахь заримдаг гийгүүлэгч өмнө, хойноо эгшигтэй бичигдэнэ. Жишээ нь хүр**ээд** $9+9=Э$

7 - эгшигт 7 гийгүүлэгч

$7+7=Э$

Э - эгшигтэй

эгшигт гийгүүлэгч: м, н, г, л, б, в, р

- 1 Тодруулсан балархай эгшгийн өмнө болон хойно орсон гийгүүлэгч эгшигт гийгүүлэгч бол 7, заримдаг гийгүүлэгч бол 9 гэсэн тоогоор тэмдэглээрэй.

ха**в**ар, ө**в**өл, цэлм**эг**, мөр**өн**, тэнг**эр**, чан**ар**, айра**г**, өр**өм**

- 2 Дараах үгсээс $7+7=Э$ загварт тохирох үгийг олж тодруулан будаарай.

шугам

үзэг

дэвтэр

үлгэр

зураг

будаг

цэцэг

9 - заримдаг 9 гийгүүлэгч

$9+7=Э$

Э - эгшигтэй

заримдаг гийгүүлэгч: ц, ж, з, с, д, т, ш, ч, х

- 3 Өгүүлбэрээс $9+7=Э$ загварт тохирох үгийг олж 9, 7 гэж тэмдэглээрэй.

Шиврээ бороотой ⁹өдөр⁷ нам хонхор газар манан татаж, уулын оройгоор будан суунаглана.

- 4 Зөв харгалзуулаарай.

А. үнэр, лууван
намар, үнэг

надад, үндэс,
нухаш, бодис

хөөрхөн, бодол,
өдөр, орчин

$9+7=Э$

$7+7=Э$

$9+9=Э$

Б.

$9+9=Э$

$7+7=Э$

$9+7=Э$

сарлаг

үхэр

тором

модод

- 5 Дүрэмд тохирох үг тус бүр хоёрыг бичээрэй.

$9+9=Э$

$7+7=Э$

$9+7=Э$

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:

1 2 3 4 5

Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Дараалсан гурван гийгүүлэгчийн гуравдугаар гийгүүлэгч нь **хоолойн г, хэлний үзүүрийн н** хоёрын нэг нь байвал н ба г-ийн өмнө богино эгшиг бичнэ. Үүнийг дараалсан гурван гийгүүлэгчийн дүрэм гэнэ.

Жишээлбэл: аньсага, бортого, ганзага, жинхэнэ, зулзага, оньсого, турсага, хавтага, харцага, хоромсого, хундага, чагтага, чандага, чогчиго, эрдэнэ,

1 Дараах үгсийг ангилан бичээрэй.

санагдана, харцага, нойрсоно, халбага, тарвага, хөгжилдөнө, оньсого зулзага, үүлшинэ, үзэгдэнэ,

Хэлний үзүүрийн "н"-тэй үгс

Хоолойн "г"-тэй үгс

2 Дараалсан гурван гийгүүлэгчийг эгшигжүүлж байгаа эгшгийг будаарай.

халбага

зулзага

тоглоно

харагдана

хөгжимдөнө

уралдана

3 Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрэмтэй үгийг үйл үг, нэр үгээр нь зөв харгалзуулаарай.

янзага

бодогдоно

чогчиго

жинхэнэ

нэр үг

үйл үг

оньсого

харагдана

үзэгдэнэ

аньсага

4 Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр бичигдсэн үгийг олж тэмдэглээрэй.

Өгүүлбэрүүд

Хүүхдүүд оньсого таалцан тоглоно. Би хулгана, тарвага, зулзага, янзага гэсэн үгийг бичиж сурлаа. Алсын бараа харагдана.

5 Тохирохыг зөв залган бичээрэй.

харагд

бодогд

санагд

үзэгд

давт

нө

на

нэ

но

харагдана

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:

1 2 3 4 5



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Хүн, хот суурин, уул ус, юмс үзэгдэл зэрэгт оноож өгсөн нэрийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Дамдины Сүхбаатар, Улаанбаатар хот, Энх тайвны гудамж, Богд уул, Орхон гол, Шувуун саарал морь, Банхар нохой гэх мэт.

1 Оноосон нэрийг олж дугуйлаарай.

А. монгол хүн, монгол бүжиг, монгол дуу, Монгол улс

Б. охин, Наран, өвөө, эмээ, хүү, ээж

В. нуур, гол, Орхон гол, мөрөн, цөөрөм

Г. хурга, ишиг, ботго, Халзаадай, тугал

2 Дугуйлсан үг оноосон нэр бол ☒, оноосон нэр биш бол ☒ тэмдэглэгээ хийгээрэй.

☐ Охин бүжгийн хичээлд суув.

☐ Бүжгийн хичээлд Солонго суув.

☐ Хурга эхийгээ хөхөв.

☐ Хөөрхөн Халзаадай эхийгээ хөхөв.

☐ Нуурын эргээр зугаалав.

☐ Дүүтэйгээ Хяргас нуурын эргээр зугаалав.

3 Зургийг ажиглаад, цэгийн оронд тохирох оноосон нэрийг нөхөж бичээрэй.



..... нар сагсан бөмбөг тоглов.



Гэр бүлээрээ..... нуурын эргээр зугаалав.



.....ууланд алхав.

4 Зөв харгалзуулаарай.

Япон улс

улс орон

Онон гол

Сэлэнгэ мөрөн

аймаг сум

Австрали улс

Сүхбаатар аймаг

газар нутаг

Ховд аймаг

Богд хан уул

гол мөрөн

Хяргас нуур

Туул гол

Орхон гол

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: (1) (2) (3) (4)



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

1 Оноосон нэрсийг уншаад, ангилан бичээрэй.

Өвөрхангай аймаг, Хэрлэн гол, Солонгос улс, Увс нуур, Орхон гол,
Завхан аймаг, Отгонтэнгэр уул, Мандал сум, Монгол улс, Их богд уул

улс орон

аймаг сум

газар нутаг

гол мөрөн

2 Эхэд байгаа оноосон нэрийг будаж тодруулаарай.

Монгол орон

Монгол орон нь хангай, говь хосолсон байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газар нутагтай. Хэрлэн, Онон, Орхон, Сэлэнгэ гээд томоохон гол мөрөнтэй. Увс, Хяргас, Буйр, Хөвсгөл, Хар-Ус гэх мэт нуур цөөрмүүд олон бий. Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны Улстай хиллэдэг. Хүүхдүүд ээ! Монгол орныхоо талаар дэлгэрүүлэн судлаарай.

3 Цэгийн ороонд оноосон нэрийг нөхөж бичээрэй.

нөхөх үг

Өвөрхангай

Хархорин

Орхон гол

Гятрууны



.....аймгийнсумаас 132 км зайтай, Орхон голын баруун биед цутгах Улаан голд үүссэн 20 гаруй метр өндрөөс буух 10 орчим метр өргөн хүрхрээ юм. ньнуруунаас Хархорин сум хүртэлх 130 километр газарт галт уулын хүрмэн чулуун дундуур урсдаг.

4 Өөрийн мэддэг оноосон нэрийг бичээрэй.

улс орон

аймаг, сум

гол, мөрөн

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ: 1 2 3 4